



ДУНДГОВЬ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН
ТОГТООЛ

2021 оны 10 сарын 01 өдөр

Дугаар 106

Мандалговь

Үндсэн хөрөнгө бүртгэх зөвшөөрөл
олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.3, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2021 оны 84 дүгээр тогтоол, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2020 оны 30 дугаар тогтоолоор батлагдсан “Орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ийн 1 дүгээр зүйлийн 1.2, 4 дүгээр зүйлийн 4.3 дахь хэсгийг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ НЬ:

Нэг: Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар Өндөршил суманд барьж ашиглалтад оруулсан нийт 1,000,000,000 /Нэг тэрбум/ төгрөгийн өртөг бүхий барилга, эд хөрөнгийг Өндөршил сумын Цэцэрлэгийн үндсэн хөрөнгийн дансанд хавсралтын дагуу бүртгэхийг зөвшөөрсүгэй.

Хоёр: Өндөршил сумын Цэцэрлэгийн эрхлэгчийн үүргийг түр орлон гүйцэтгэгч (Д.Номин-Эрдэнэ)-д дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай.

- 2.1. Комисс томилон хөрөнгө хүлээн авч бүртгэх ажлыг байгууллагын өмч хамгаалах байнгын зөвлөлийн хяналт дор холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах;
- 2.2. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусгах;
- 2.3. Энэ тогтоолын биелэлтийг 2021 оны 11 дүгээр сард багтаан Орон нутгийн өмчийн газарт ирүүлэх;

Гурав: Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг дарга /Ц.Мөнхбат/-д үүрэг болгосугай.



ДАРГА С.ОД-ЭРДЭНЭ

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
Тэргүүлэгчдийн 2021 оны 10 дугаар сарын 01-ний
өдрийн 106 дугаар тогтоолын хавсралт



Өндөршил сумын Цэцэрлэгийн үндсэн хөрөнгөд бүртгэх хөрөнгийн жагсаалт

№	Хөрөнгийн нэр	Хэмжих нэгж	Нэгжийн үнэ	Тоо ширхэг	Нийт үнэ
1	Барилга	ш	915 342 533	1	915 342 533
2	Худаг	ш	66 214 698	1	66 214 698
3	Хашаа	ш	15 280 897	1	15 280 897
4	Мод	ш	15 000	33	495 000
5	Гэрэлтүүлэг	ш	666 718	4	2 666 872
Нийт дүн					1 000 000 000 /нэг тэрбум төгрөг/